

ПОСТ АЖ ҮЙЛДВЭРЖИЛТ, ДАЯАРШИЛ

*Р.Буянжаргал**

Дэлхийн тэр аяараа даяршиж байна. Ер нь дэлхийн даяршлын тухай асуудал тийм ч алс хол, цоо шинэ ухагдахуун биш юм. Мянган жилийн өмнө:

- Үндэсний соёл
- Үндэсний соёл иргэншил үүсч улмаар хөгжин цэцэглэж байсан.

Зуун зуун жилийн туршид соёл иргэншил, соёл, эдийн засаг, худалдааны хооронд харилцаа холбоо улам бэхжин хөгжиж улмаар гүйцэтгэх үүрэг, агуулга хэлбэр гэрээ ондоосон тусгаарлагдаж байсан байна. Энэ үед дэлхийн хүн ам экватороос умар зүгт шилжин жил ирэх тутам олширон, газар нутагтаа оршин тогтнож зуун зуунд улам бэхжиж байлаа. Энэ тухай ярих асуудлын суурь үндэс бол дэлхийн хүн амын соёл, иргэншил, хүн төрөлхтний түүхэн хөгжил юм. ХХ зууны сүүлийн арван жилд дэлхийн тодорхой хэсэгт зах зээл тусгаарлагдаж үүсч холбоо, тээвэр тодорхой түвшинд хөгжиж үр өгөөж нь сайжирч үүний тусламжтай сая хүн амын хооронд гэрээ хэлцэл хийгдэж, тодорхой газар нутагт тогтвортой байршин шинжлэх ухааны нээлт улам олширч ирсэн. ХХ зууны сүүлийн 35 жилд даяаршлын явц цоо шинэ зарчмаар бэхжиж хүн төрөлхтний хувь заяаг тодорхойлох болсон. Энэ нь янз янзын хэлбэртэй, янз янзын орчинд хэрэгжих болсон. Энэ бүхнийг дараах чиглэлээр илүү тодруулан авч үзье. Үүнд:

1. Хүн ам зүй экологид нөлөөлөх хүчин зүйл: Энэ нь өөр хоорондоо нягт харилцан холбоотой хоёр үндсэн хүчин зүйлээс үүдэлтэй гэж үзэж болно. Үүнд: ХХ зууны хагас зуун тус бүрд гаригийн хүн ам 1.3 дахин өссөн. Харин ХХ зууны эхний хагаст 1.5 дахин, сүүлийн хагаст 2.4 дахин өсчээ. НҮБ-ын прогнозоор ХХI зууны эхний хагаст 1.6 дахин өсөх төлөвтэй байна.

Харин дэлхийн хүн амын хэрэгцээ бүр түргэн өсөх магадлал их байна. Гэтэл газраа боловсруулж эзэмших боломж багасч улмаар цэнгэг ус, ойн болон байгалийн баялаг, эрдэс мөхөн элдээрийн нөөц хүрэлцэхгүй болох төлөвтэй. Агаар мандал бохирдож хүн төрөлхтөнд үхэл, мөхөл, аюулын дохио хангинах элбэгших боллоо. Дэлхийн дайны үе багасч бохирдож байна. Амьд амьтан амьдрах нөхцөл хомсдож, хөнөөл, хохирол ихэсч байна.

М.М.Голанскийн прогнозоор дэлхийн эдийн засагт нэг хүнд ноогдох ДНБ-ний үйлдвэрлэлийг 2005 оныг 2000 онтой харьцуулахад

* Р.Буянжаргал - ОУЭЗ-ийн дээд сургууль, ахлах багш, профессор

25% буурах юм байна. Харин 2015 онд дэлхийн түвшний ДНБ-ний үйлдвэрлэл бодитой буурна гэж тооцсон байна.

2. Техникийн хөгжлийн хүрээний даяаршил: Аж үйлдвэржилтийн үед соёл иргэншил нийгмийн бүх амьдралын хүрээнд цэцэглэн дээд эрэмбийн технологи боловсруулагдаж техникийн түвшинд техник-технологи мэдээлэлжүүлэлтийн орон зай эрс өргөжиж харилцаа холбоо, тээврийн сүлжээний үүрэг агуулгаараа эрс ялгаран хүчтэй хөгжиж байна.

Аж үйлдвэржилтийн эриний эхний үетэй харьцуулахад улс орнуудын хооронд технологийн ялгаа эрс өсч байна.

XX зууны хөгжиж байгаа орнуудад пост аж үйлдвэржилтийн үйлдвэрлэлд технологийн арга бүрэлдэн тогтсон. Аж үйлдвэржих үе эхлэх хүртэл хөдөө аж ахуй, орон сууцны барилгажилт гар үйлдвэрт технологийн хэвшил давамгайлан хөгжиж ноёрхолоо тогтоож байсан. Улс орнууд технологи илүү сайн ашигласнаар хөгжлийн хувьд дунд болон доогуур түвшинд байгаа орнуудад дараах бараа үйлчилгээг экспортлох болсон. Үүнд:

- Компьютер
- Хангамжийн программ
- Үүрэн телефон
- Сансрын холбоогоор үйлчлэх болжээ. Үүний үр дүнд асар их хэмжээний ашиг олж эхэлсэн.

3. Эдийн засгийн даяаршил: Нийгмийн эдийн засгийн хөгжлийг тодорхойлох түүний гүйцэтгэх үүрэг, хөшүүргийг тогтоох, чиг хандлагыг шийдвэрлэх эрх зүйн орчныг баталгаажуулах, эдийн засгийн даяаршлыг өргөн хүрээнд бэхжүүлэх, үндэсний эдийн засгийг улам боловсронгуй болгоход эдгээрийн хоорондын уялдаа холбоог нарийвчлан нягтлан холбож өгөх ийм өндөр түвшинд хүртэл тогтоход, дэлхийн эдийн засгийн цогцолбор үйл ажиллагаа онцгой үүрэг гүйцэтгэнэ.

К.Маркс хөрөнгөтний нөхөн үйлдвэрлэлийг нарийн судлан дэлхийн аж ахуйн тогтолцоонд үндэсний эдийн засгийг багтааж түүнд хязгаар тогтоож болохгүй гэсэн санааг дэвшүүлсэн байна.

Гэвч М.М.Голанский түүнээс илүү их тодорхой асуудлуудыг дэлхийн аж ахуйн тогтолцоонд багтаах санааг дэвшүүлсэн байна. М.М.Голанский дэлхийн аж ахуйн тогтолцоонд өөрийн (хувийн) нөхөн үйлдвэрлэлийн тогтолцоог багтааж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж үзжээ. Тэрбээр “Одоо үндэсний түвшинд төдийгүй дэлхийн түвшинд ч эдийн засгийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн оновчтой харилцааг тогтоох хэрэгтэй” гэж үзсэн. Энэ нь нийгмийн үйлдвэрлэх хүчнийг

хамран эзэмших шинэ үе шатны үндэс мөн гэжээ.

М.М.Голанскийн саналаар “хоцрогдсон бүдүүлэг улс орнуудыг хөгжлийн өндөр түвшинд хүрэх нөхцөл боломжийг хангаж өгөх шаардлага бий” гэсэн байна.

Э.Кочетов өөрийн дүгнэлтэндээ нилээд болгоомжилж явдаг байна. Гэвч Э.Кочетов өргөтгөсөн нөхөн үйлдвэрийн үе шат бүр нь дэлхийн аж ахуйн хамтын ажиллагааны үндэсний баялаг бий болох нөхцлийг бүрдүүлж дэлхийн орлогын эх сурвалж болох гол цөм нь болжээ.

4. Геободлогын даяаршил: Геободлогын газар нутгийн талаарх чиг хандлагыг ажиглаж үзэхэд дэлхийн даяаршилтаа сэргөгдөх чиглэл харагдаж байгаа юм.

XX зууны сүүлийн хагаст холбооны улс орнуудын үүрэг суларч, колончлох засаглал нуран унаж засгийн дээд эрх шинэ улс орнууд үүссэн. Энэ үед Орос, Америк хоёрт дэлхийн геободлогын гол хүч төвлөрсөн.

Үүнтэй холбогдуулаад Збигнев Бжезинский дээрхи хоёр улс орны бодлого үзэл баримтлалыг үндсэнд нь тодорхойлсон З.Бжезинский бүр онцлог 1999 онд НАТО-гийн баримтлах үзэл баримтлалын чиглэлийг нарийвчлан нягтлан томъёолжээ.

5. Нийгэм-соёлын даяаршил: Нийгэм соёлын хүрээний далд буй мөн чанар ихээхэн төвөг бэрхшээлтэй, эсрэг тэсрэг шинж чанартай асуудал бололтой.

Энэ салбарт:

- Шинжлэх ухаан
- Боловсрол
- Ёс зүй
- Ертөнцийг үзэх үзэл зэрэг ухагдахууныг багтаана.

Нэг талаас нь аваад үзэхэд даяаршлын шинжтэй шинжлэх ухааны дэвшлээр илэрхийлэгдэнэ гэдэг нь тов тодорхой байна. Ийм учраас юуны урьд:

- Үндсэн хил хязгаарын утга учрыг ойлгох
- Эрдэм мэдлэг, үзэл бодлоо чөлөөтэй солилцох
- Боловсролын тасралтгүй сургалтын ерөнхий тогтолцоог бүрдүүлэх
- Сурган хүмүүжүүлэх бодлого чиглэлээ тогтоох
- Дээд эрэмбийн мэдээллийн технологид түшиглэх
- Соёлын үнэт зүйлийн солилцоог эрчимтэй хөгжүүлэх
- Үндэсний олонхийн эрх ашигт харш соёл түгээх эсрэг хүчтэй тэмцэх хэрэгтэй болж байна.

Үүний тулд юуны түрүүнд интернет харилцаа холбоог өргөн цар

хүрээтэй ил тод ажиллах нөхцлөөр бүрэн хангах үүнийг хэрэгжүүлэх хүлээн зөвшөөрөхийн тулд XXI зууны эхэн үед Питарим Сорокины хэлснээр цогцолбор нийгэм-соёлын давхрааг бий болгох.

Аурелио Печчин зөн билгээрээ урьдчилан төсөөлж байсан үзэл баримтлалтай нийцүүлэн хамгийн энэрэнгүй цоо шинэ нийгэм байгуулах явдал юм гэнэ.

Дэлхийн даяаршлын ач холбогдлыг С.М.Рогов өндөр үнэлж “даяаршлын үр дүнд хүмүүсийн хооронд бие биенээ хүндэтгэсэн, туслалцаа үзүүлсэн мэдээлэл, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хүссэн, сонирхсон түвшиндээ хүргэн ашиглах өргөн боломж хүн төрөлхтний өмнө бүрэн нээлттэй болно” гэжээ.

1996 онд олон улсын худалдааны байгууллага Америк улсаас санаачлан оруулсан мэдээллийн технологи солилцох зөвшилцлийг батлан мөрдсөнөөр дэлхийн түвшинд мэдээллийн технологийн солилцооны зах зээлийн эргэлт 600 сая ам.долларт хүрсэн. Мөн 2000 онд 45 оронд мэдээллийн технологи солилцох болон зөвшилтэй уялдуулан дараах бүтээгдэхүүний гаалийн татварыг хүчингүй болгон цуцлана. Үүнд:

- Харилцаа холбооны тоног төхөөрөмж
- Прорамм хангамж
- Компьютер зэрэг бүтээгдэхүүн орж байна.

1997 онд 69 орон оролцсон мэдээллийн технологи солилцох зөвшилцлийг дүгнэхэд тус улс орны 95% нь мэдээллийн технологийн зах зээл бүрэн либералчлагдсан байжээ.

Ийнхүү мэдээллийн технологийн зах зээл даяарчлагдах болсноор доорх бүтээгдэхүүнийг чөлөөтэй шилжүүлэн арилжих нөхцөл хангагдсан байна. Үүнд:

- Мэдээллийн солилцоо
- Мэдээллийн төрөл бүрийн үйлчилгээ
- Харилцаа холбооны бүх төрлийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл
- Компьютер дамжуулагчийн тоног төхөөрөмж түүний угсрах эд анги орж байна.

Харин дэлхийн нэртэй нэн том супер үндэстэн дамнасан корпорациуд дэлхийн хөгжилтэй орнуудад байршин энэ зах зээлийг хатуу хяналтандаа байлгадаг.

1997 онд 102 улс орон оролцсон санхүүгийг зах зээлийг либералчлах тухай дэвшил байгуулагдсанаар санхүүгийн зах зээлийн эргэлт 38 их эринд хүрсэн.

Орчин үеийн нийгмийн зааг хязгаар даяаршлын мөн чанарыг

**Дэлхийн хүн амын эдийн засаг, цэргийн чадавхид олон
улсын нэгтгэл, бүлэглэлийн эзлэх хувь /хүснэгт №2/**

Соёл иргэншил, түүнд багтах улс орон	Хүн ам	Эдийн засгийн чадавхи				Цэргийн чадавхи		
		ДНБ	Хөрөнгө оруулалт	Гадаад худалдаа	Засгийн газрын өр	Цэргийн зардал	Цэргийн тоо	Цахилгаан зэвсэг
1. Европын Холбоо	7	24	43	19	40	22	14	2
2. НАТО	12	51	54	35	74	57	21	43
3. Их долоо	11	49	63	40	62	56	15	43
4. ЭЗХАХ	11	72	71	50	76	64	24	43
5. АНДЭНийгэмлэг	34	29	25	36	21	18	21	1
6. Нөхөрлөлийн орнууд	5	2	2	2	1	3	10	52

**Дэлхийн бүх нутаг, зарим орны хөгжлийн төвийн
хүн амын хоорондын хамаарал. (Хүснэгт 3)**

Бүс нутаг, улс орон	Хүн ам /1995/		Нэг хүнд ноогдох ДНБ			Насдалт		Нэг хүнд ноогдох эрчим хүчний хэрэглээ	
	Сая хүн	Дэлхийд эзлэх %	1995 оны \$	Дэлхийд эзлэх %	1985-1995 оны жилийн дундаж %	1995 он нас	Дэлхийн дундаж %	1994 оны /кв/	Дэлхийн дундаж харьцуулсан
➤ Орлогын түвшин өндөр орнууд	902	15.9	24930	511	1.9	77	115	5066	354
- Америк	263	4.6	26980	553	1.3	77	115	7819	546
- Герман	82	1.4	27510	564	-	76	113	4128	288
- Япон	125	2.2	39640	812	2.9	80	119	3826	269
➤ Орлогын түвшин дундаас доогуур орнууд	4771	84.1	1090	22.3	0.4	65	97	790	52
- Африк /Магриба ороогүй/	583	10.3	490	10.0	-1.1	52	78	237	17
- Дорнод Ази, Номхон далайн бүс. Үүнээс:	1706	30.1	800	16.4	7.2	68	101	593	41
- Хятад,	1200	21.2	620	12.7	8.3	69	103	248	17
- Өмнөд Ази. Үүнээс:	1243	21.9	350	7.1	2.9	61	91	222	15
- Энэтхэг	929	16.4	340	7.0	3.2	62	93	664	46
- Европ, дундад Ази.	488	8.6	2220	45.5	-3.5	68	101	2647	186
- Үүнээс Орос	148	2.6	2240	45.9	-5.1	65	97	4014	280
- Хойд Америк, Ойрхи Дорнод	272	4.8	1780	36.5	-0.3	66	99	1220	85
- Латин Америк, Карибын орнууд	478	8.8	3220	66.0	0.3	69	103	660	67
➤ Орлогын түвшин багатай орнууд /Энэтхэг, Хятад ороогүй/	1050	18.5	290	5.9	-1.4	56	84	134	19.2
➤ Дэлхийн түвшин	5673	100	4880	100	0.8	67	100	1433	100

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Яковец Ю.В /Глобализация и взаимодействие цивилизаций/
Международ. Ин-т П.Сорокина-Н, Кондратьева-М: ЗАО
“Экономика хуудас-6
2. Яковец Ю.В /Глобализация и взаимодействие цивилизаций/
Международ. Ин-т П.Сорокина-Н, Кондратьева-М: ЗАО
“Экономика” хуудас-8
3. Яковец Ю.В /Глобализация и взаимодействие цивилизаций/
Международ. Ин-т П.Сорокина-Н, Кондратьева-М: ЗАО
“Экономика” хуудас-10
4. Яковец Ю.В /Глобализация и взаимодействие цивилизаций/
Международ. Ин-т П.Сорокина-Н, Кондратьева-М: ЗАО
“Экономика” хуудас-11
5. Яковец Ю.В /Глобализация и взаимодействие цивилизаций/
Международ. Ин-т П.Сорокина-Н, Кондратьева-М: ЗАО
“Экономика” хуудас-12